



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 64

Мандалговь

Х.Эрдэнэбатыг Их газрын чулууны уулын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны Гурвансайхан сумын Ерлөг уул орчим хариуцсан байгаль хамгаалагчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 6 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Их газрын чулууны уулын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны Гурвансайхан сумын Ерлөг уул орчим хариуцсан байгаль хамгаалагчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Халтар овогтой Эрдэнэбат 56.3 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Х.Эрдэнэбатын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2022 оны ... дугаар сарын
...-ны өдрийн ... дугаар тогтоолын хавсралт



**Их газрын чулууны уулын тусгай хамгаалалттай газар нутгийн
хамгаалалтын захиргааны Гурвансайхан сумын Ерлөг уул орчим
хариуцсан байгаль хамгаалагчийн албан тушаалд
нэр дэвшүүлсэн Х.Эрдэнэбатын тухай дүгнэлт**

1. Х.Эрдэнэбат нь 1996 онд Дундговь аймгийн Гурвансайхан суманд төрсөн. 26 настай, эрэгтэй
2. Боловсрол: 2013-2017 онд Газарчин дээд сургуулийг Аялал жуулчлал, байгаль хамгаалал, экологич мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Х.Эрдэнэбаатарын тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Их газрын чулууны уулын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны Гурвансайхан сумын Ерлөг уул орчим хариуцсан байгаль хамгаалагчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ